



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 8/139

Мөрөн сум

Ой хээрийн түймрээс урьдчилан
сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.16, 17.2.17, 17.2.18, 17.2.19, 17.2.20, 17.2.21, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2023 оны 01 дүгээр албан даалгавар, аймгийн Шуурхай штабын 2023 оны 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ой хээрийн түймэр гарах байгалийн нөхцөл бүрдсэн түймрийн эрсдэлтэй үе эхэлсэнтэй холбогдуулан ойгоос мод бэлтгэх, ойн цэвэрлэгээ, арчилгаа хийх, үр, мөчир бэлтгэх, ойн дагалт нөөц ашиглах, аялал зугаалга зэрэг аливаа үйл ажиллагааг 2023 оны 04 дүгээр сарын 04-ны өдрөөс эхлэн мөн оны 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хугацаагаар түр зогсоосугай.

2. Түймрийн эрсдэл бүхий хуурайшилтын улирал эхэлж байгаатай холбогдуулан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутагтаа зохион байгуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, эргүүл хяналт шалгалт хийх, байнгын ажиллагаатай пост гаргах, түймэр гарсан үед хүн хүч, техник хэрэгслийг дайчлан шуурхай унтраах, шаардагдах зардал, багаж хэрэгсэл, хүнсний нөөцийг хангах, мэдээллийг шуурхай дамжуулах хариуцлагатай жижүүр ажиллуулах зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Ой, хээрийн түймрийн хуурайшилтын үед иргэд, төрийн албан хаагч, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хуваарийн дагуу эргүүл хийлгэж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал), сумын Засаг дарга нарт, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэгдсэн байдлаар зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (Хурандаа Ё.Пүрэвсүрэн) нарт тус тус даалгасугай.

4. Түймрийн аюултай зэрэглэлийн үед үүлэнд зориудаар нөлөөлөх ажиллагааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулж, мэдээллийг цаг тухай бүрд нь холбогдох газруудад мэдээлэхийг Ус, цаг уур, орчны шинжилгээний төв (Б.Өнөрбат)-д, ой, хээрийн түймэр гарсан шалтгаан нөхцөлийг хуулийн хугацаанд шалган тогтоож, эзэн холбогдогчдод хариуцлага тооцож, авсан арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа А.Алтанцоож) нарт тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ), хэрэгжилтэд хяналт тавьж явц, үр дүнг танилцуулахыг Онцгой байдлын газар (Ё.Пүрэвсүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР

6712010535